

Заавал шалга! Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг!

Хөдөлмөр эрхлэгч ба ажил олгогчид
зориулсан дүрэм юм!

Фүкүи мужийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

2024 оны
10 сарын 5 өдрөөс
Нэг цагийн үнэлгээ

984 иен

Өмнөх жилтэй харьцуулахад

53 иен
НЭМЭГДСЭН

モンゴル語版

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь ажил эрхэлж буй бүх хүнд
хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээг баталж буй тогтолцоо болно.

Цахим
хуудаснаас
харна уу

Хөдөлмөрийн хөлсний
доод хэмжээний
талаарх цахим хуудас
(зөвхөн Япон хэл дээр)



最低賃金 特設サイト



Хөдөлмөрийн хөлсний доод
хэмжээний талаар лавлах бол
Фүкүгийн Хөдөлмөрийн
товчоо болон ойролцоох
Хөдөлмөрийн стандартын
хяналтын газарт хандана уу.



福井労働局



Хөдөлмөрийн хөлсийг
нэмэгдүүлэх тусгайлан
боловсруулсан хуудас
(зөвхөн Япон хэл дээр)
Хөдөлмөрийн хөлсийг
нэмэгдүүлэхэд
чиглэсэн дэмжлэгийн
бодлогыг байршуулсан.



賃金引上げ特設ページ



Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч та бүхэнд

業務改善
助成金

Хамгийн ихдээ
6 сая иений
мөнгөн дэмжлэг
үүзүүлнэ



“Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тогтолцоо” нь, хөдөлмөр хийж буй хүн бүхэнд **хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээг (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ) баталгаажуулах тогтолцоо юм!**

Нас болон цагийн ажилтан, оюутан зэргээс үл хамааран бүх хөдөлмөр эрхлэгчдэд эрх тэгш үйлчилнэ.

Хэрхэн харах вэ?

Шалгахыг хүсэж байгаа хөдөлмөрийн хөлс^(*1)-нийхөө нэг цагийн үнэлгээг гаргаад, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (нэг цагийн үнэлгээ)-тэй харьцуулж үзье!

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харьцуулах арга Таны хөдөлмөр эрхэлж буй аймаг хот дүүргийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бичнэ үү. (*2)

1 Нэг цагийн үнэлгээний тохиолдол	Нэг цагийн хөлс ¥	≥	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн хөлс) ¥				
2 Нэг өдрийн үнэлгээний тохиолдол	Нэг өдрийн хөлс ¥	÷	Нэг өдрийн ажлын дундаж цаг цаг	=	Нэг цагийн хөлс ¥	≥	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн хөлс) ¥
3 Нэг сарын үнэлгээний тохиолдол	Сарын хөлс ¥	÷	Нэг сарын ажлын дундаж цаг цаг	=	Нэг цагийн хөлс ¥	≥	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн хөлс) ¥

4 Дээрх 1, 2, 3 нэгтгэсэн байх тохиолдол

Тухайлбал, үндсэн цалин нь өдрөөр тооцож, бусад нэмэгдэл (хөдөлмөрийн нэмэгдэл) нь сараар тооцдог тохиолдол

① Үндсэн цалин (Өдрийн хөлс) → 2-р тооцооллоор нэг цагийн үнэлгээг бодож гаргана.
② Нэмэгдэл хөлс (сарын цалин) → 3-р тооцооллоор нэг цагийн үнэлгээг бодож гаргана.
③ ① болон ②-ыг нэмсэн дүн ≥ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн үнэлгээ)

(*1) Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулж үзэхдээ дараах нэмэгдлүүдийг оролцуулж тооцохгүй.
① Нэмэгдэл цалин (Гэр бүлтэй болсны нэмэгдэл г.м) ② Нэг сарын хугацаа өнгөрөх тутамд олгох нэмэгдэл цалин (урамшуулал г.м) ③ Тогтсон ажлын цаг хэтэрсэн тохиолдолд тооцогдох нэмэгдэл хөлс (илүү цагийн нэмэгдэл г.м) ④ Тогтсон ажлын өдрөөс гадна ажилласан өдрийн нэмэгдэл хөлс (амралтын өдрийн нэмэгдэл хөлс г.м) ⑤ Оройны 22 цагаас өглөө 5 цаг хүртэлх ажлын цагт төлөгдөх хөдөлмөрийн хөлсөнд, өдрийн ажлын цагийн хөлсний үнэлгээний зөрүү дүнг (шөнийн цагийн нэмэгдэл г.м) тооцно. ⑥ Ажил тасалж, хоцроогүйн нэмэгдэл, унааны нэмэгдэл болон гэр бүлийн нэмэгдэл цалин гэх мэт
(*2) Дэлгэрэнгүй тооцоолол хийх арга болон ажлын гүйцэтгэл, борлуулалтын хувиас олгох хөлсийг тооцоолол хийх арга зэргийг Хөдөлмөрийн товчоо болон Хөдөлмөрийн стандарт хяналтын газраас лавлана уу.

Ажил олгогч болон хөдөлмөр эрхлэгч нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг заавал нягтлах хэрэгтэй.



Ухаалаг утас болон гар утсаа ашиглан өөрийн амьдарч буй орон нутгийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодруулж харна уу!
(зөвхөн Япон хэл дээр)

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч та бүхэнд

Хөдөлмөрийн хөлс нэмэгдүүлэхийг дэмжих тэтгэмжийг идэвхтэй ашиглацгаая.

業務改善助成金

Хамгийн ихдээ 6 сая иений мөнгөн дэмжлэг үзүүлнэ

Бизнесийн үйл ажиллагааг сайжруулахад үзүүлэх дэмжлэгийн дуудлагын төв

0120-366-440

Дэлгэрэнгүйг эндээс харна уу. (зөвхөн Япон хэл дээр)

業務改善助成金

検索



Олгох нөхцөл

- 1 ажлын байрны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх
 - 2 Нэмэгдүүлсэн дүнгээр ажилчдад цалин олгох
 - 3 Үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулахад тусгай тоног төхөөрөмж зэргийг нэвтрүүлэх
 - 4 Ажилтан халсан, цалинг бууруулсан зэрэг оглолтод үл нийцэх хүчин зүйл байхгүй.
- Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад зарцуулсан зардлын зарим хэсгийг нөхөн олгох.**

Дэмжлэгийг олгох хүртэлх дараалал

- 1 Олгохыг хүссэн өргөдөл, бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг ажлын байр нь байгаа орон нутгийн Хөдөлмөрийн газарт мэдүүлнэ.
- 2 Олгохоор шийдвэрлэсний дараа хүргүүлсэн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах.
- 3 Хэрэгжүүлсэн үр дүнгийн тайлан, олгохыг хүссэн өргөдлийг Хөдөлмөрийн газарт мэдүүлэх
- 4 цалин нэмэгдлийг олгох

Мэргэжилтнээс үнэ төлбөргүй зөвлөгөө авах

Хөдөлмөрийн хөлс нэмэгдүүлэлттэй холбоотой ямар нэгэн асуудал байвал Хөдөлмөрийн нөхцөл байдал сайжруулалтыг дэмжих төвд ирж зөвлөгөө авна уу.

Дэлгэрэнгүйг эндээс (зөвхөн Япон хэл дээр)

働き方改革推進支援センター

検索

Хөдөлмөрийн нөхцөл байдал сайжруулалтыг дэмжих сан

Японы Засгийн Газрын Санхүүгийн Корпорацид ажлын байран дээрх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх бизнес эрхлэгчид тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хийдэг.

Дэлгэрэнгүйг эндээс (зөвхөн Япон хэл дээр)

働き方改革推進支援資金

検索

リサイクル適性(A)
この印刷物は、印刷用の紙でリサイクルできます。